

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛД ЧӨЛӨӨТ СЭТГЭЛГЭЭГЭЭР ХАНДСАН БҮТЭЭЛ

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, доктор (Sc.D).

Түлхүүр үгс: чөлөөт хэвлэл, нэг сэдэвт бүтээл, хэвлэлийн эрх чөлөө, мэргэжлийн ёс зүй, хэвлэлийн либертари онол, эрх зүйн зохицуулалт, медиа боловсрол

Орчин үеийн Монголын сэтгүүл зүйн хөгжилд ажиглагдаж буй шинэ үзэгдлийн нэг бол сүүлийн жилүүдэд сэтгүүл зүй судлаачдын эгнээ тэлж, ОНМХ-ийн түүх, онол, практикийн асуудлуудыг тал бүрээс нь хөндсөн судалгааны бүтээлүүдийн тоо эрчимтэй нэмэгдэж буй явдал юм. Манай туршлагатай судлаачдын бүтээлүүдээс гадна эрдмийн зэрэг хамгаалсан шинэ докторуудын арваад нэг сэдэвт бүтээл хэвлэгдэн гарч, олны хүртээл болсон нь үүний тод жишээ мөн. Тухайлбал, доктор Л.Ариуны “Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл” (2008), Н.Мөнхзоригийн “Монголын шог, хошин нийтлэл: уламжлал, шинэчлэл” (2012), Н.Ариунзаяагийн “Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж” (2014), Б.Галааридын “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил” (2018), Т.Өнөрсайханы “Монголын арилжааны телевизүүд: түүх, онол,

арга зүй” (2019), Т.Батзоригийн “Монголын эвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа” (2019), М.Наранчимэгийн “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй” (2019), Д.Сандагсүрэнгийн “Л.Түдэвийн нийтлэлийн онцлог, ур чадвар” (2021) судалгааны бүтээлүүдийг нэрлэж болно.

Миний бие судлаач, багш хүний хувьд сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүдийн талаар цуврал шүүмжлэлт өгүүлэл бичиж байгаа бөгөөд доктор Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн, Б.Болд-Эрдэнэ, Ч.Чойсамба, Ц.Цэмбэл, Г.Сумъяа, Н.Мөнхзориг, Т.Ганди, С.Батмөнх, Д.Сандагсүрэн нарын бүтээлийн талаар бичсэн өгүүллүүд “Сэтгүүл зүй” сэтгүүл, “Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд” 18 ботид нийтлэгдсэн юм. Энэ удаа сэтгүүлч, зохиолч, доктор Б.Галааридын “Чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил” нэг сэдэвт бүтээлд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилго болгож байна. Энэ нь судлаач Б.Галааридын бүтээл чөлөөт хэвлэлийн хөгжлийн асуудлыг нэлээд өргөн хүрээнд авч үзээд анхаарал татахуйц үнэлэлт өгсөн цөөн бүтээ-

лийн нэг, нөгөө талаар өмнө нь гарч байсан Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын асуудлыг хөндсөн бүтээлүүдээс чухам юугаар ялгаатай гэдгийг тодруулах гэсэн зорилготой холбоотой юм.

Оршил, дүгнэлтээс гадна үндсэн гурван бүлгээс бүрдсэн нэг сэдэвт бүтээлийн “Чөлөөт хэвлэлийн үзэл баримтлал, Монголын хэвлэлийн эрх чөлөөний асуудлууд” хэмээх нэгдүгээр бүлэгт хүний эрх, эрх чөлөө ба үзэл бодлын эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт хэвлэлийн онолын сэтгэлгээний асуудлыг нэлээд өргөн хүрээнд авч үзээд Шарль Монтескье, Гегель, Жон Мильтон, Локк зэрэг нэрт философичдоос эхлээд Дэннис Маквейл, Ф.Сиберт, Т.Петерсон, У.Шрамм, Жон Мэрилл зэрэг мэдээлэл харилцааны онолыг судлаач эрдэмтдийн бүтээлүүд, мөн эрх чөлөө ба үзэл бодлын эрх чөлөөний асуудлыг хөндсөн олон улсын болон Монгол Улсын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, судалгааны бүтээлийн үндсэн асуудлын талаар тодорхой ойлголт, мэдээлэл, төсөөлөл өгч чадсан байна. Мөн Монгол Улсад чөлөөт хэвлэлийн тогтолцоо хөгжин төлөвшиж буй үйл явцыг судлахдаа Ф.Сиберт нарын “Хэвлэл мэдээллийн дөрвөн онол” буюу хэвлэл мэдээллийн авторитари онол, либертари онол, нийгмийн хариуцлагын онол, зөвлөлтийн коммунист онол, Д.Маквэйлийн Ардчилсан оролцооны онол, Хэвлэл мэдээллийн хөгжилд оролцох тухай онол, өөрөөр хэлбэл Олон нийтийн харил-

цааны зургаан норматив онолыг баримталсан нь арга зүйн хувьд зөв болжээ. Дээрх үзэл онолыг иш үндэс болгон зохиогч: “Монголын нийгмийн хувьд хаалттай, цагдан хяналттай хатуу коммунист дэглэмтэй нийгмийн тогтолцоог халсны дараа хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг ардчиллын шинэ цаг үед либертари үзэл санаа маш эрчимтэй түгэн дэлгэрч, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх туйлын хүсэл сонирхолд автсан нь бодит үзэгдэл байлаа. Тэр дундаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай туйлширсан Либертари үзэл газар авч хэвлэлүүд юуг ч бичиж болох “хязгааргүй” эрх чөлөөг эрхэмлэх болсон. Харин энэ туйлширалд цэг тавихын тулд мэргэжлийн ёс зүй, хариуцлагын тухай ярьж эхлэхтэй зэрэгцэн шинэ зууны босгонд нийгмийн хариуцлагын тухай онолын үзэл санаа Монголын сэтгүүл зүйд түгэн дэлгэрч эхэлсэн билээ” (Б.Галаарид, 2018) гэсэн зөв дүгнэлт хийсэн байна.

Судалгааны бүтээлийн энэ бүлэгт анхаарал татахуйц хэд хэдэн чухал санал дүгнэлт байгаагийн нэг нь “Шинэ толь хэмээх бичиг” сонин чөлөөт хэвлэл байсан эсэх, “Монголын үнэн” сониныг эрхлэн гаргахад монголчууд биечлэн оролцон тухай асуудал юм. Доктор Г.Дэлэгийн дараа “Шинэ толь хэмээх бичиг” сониныг судалсан эрдэмтэд Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн, М.Зулькафиль нарын ашигласан эх сурвалж нь МУИС-ийн Эрдэм шинжилгээний номын санд хадгалагдаж буй “Шинэ толь хэмээх бичиг” сонины сэтгүүлч, орчуулагч

Б.Дашцэрэнгийн Ленинградын их сургуульд оюутан байхдаа монгол бичгээс кирилл үсэгт буулгасан гар бичмэл юм. Энэ гар бичмэлийг 1990-ээд оны эхэнд тухайн үед Түүхийн тэнхимийн эрхлэгч байсан академич Ж.Болдбаатар бид хоёр МУИС-ийн захиргаанд удаа дараа хүсэлт тавьсны үндсэн дээр МУИС-ийн захиргаа Б.Дашцэрэн сэтгүүлчээс худалдан авч Эрдэм шинжилгээний номын санд хадгалуулсан юм. Сэтгүүлч Б.Дашцэрэнгийн хэлснээр Г.Дэлэг доктор ч энэ гар бичмэлийг авч ашиглаж судалгаа хийсэн бололтой юм. Дараа нь судлаачид энэ гар бичмэлийг судалгааны эргэлтэд оруулж эхэлсэн бөгөөд Н.Пүрэвсүрэн судалж магистрын зэрэг хамгаалсан бол Л.Норовсүрэн багш “Монголын нийтлэл” номын тэргүүн ботид гар бичмэлүүдийг бүрэн эхээр оруулж тодорхой тайлбар, дүгнэлт хийсэн билээ. Миний бие шинжлэх ухааны докторын диссертацыг бичих явцад энэ гар бичмэлүүдтэй танилцаж, судалгаа хийсний үндсэн дээр чөлөөт хэвлэлийн нийтлэлд байдаг зарим шинжийг ажигласан учраас судалгааны бүтээлд: “Шинэ толь хэмээх бичиг” сонин нийтлэлийн бодлого, тусгах сэдэв, харьяаллын хувьд чөлөөт хэвлэлийн олон шинж тэмдгийг өөртөө агуулж байсан” (М.Зулькафиль, 2015) гэсэн дүгнэлт хийсэн билээ. Харин “харьяаллын” гэсэн санааг доктор Г.Дэлэгийн дүгнэлийг үндэслэн хийсэн юм. Тухайн үеийн нөхцөл байдал, чөлөөт хэвлэл гаргах боломж, эрх зүйн орчин бүрдээгүй зэрэг шалтгааны

улмаас шууд утгаар чөлөөт хэвлэл мөн гэж нотлох үндэслэл бага юм. Тиймээс судлаач Б.Галааридын “...эдгээр сонин хэвлэлийг чөлөөт хэвлэл гэж шууд үнэлэн дүгнэхэд өрөөсгөл юм. Учир нь чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний тухай нийгмийг хамарсан өргөн хүрээний гүн гүнзгий үзэл санаа, түүнийг баталгаажуулсан эрх зүйн орчинд бүрэлдэн бий болж, хөгжиж төлөвшдөг болохыг чөлөөт хэвлэлийн үзэл онолуудад тодорхой тайлбарладаг” (Т.Батзориг, 2019) гэсэн дүгнэлттэй санал нэг байна. Харин “Монголын үнэн” сониныг гаргахад монголчууд биечлэн оролцсон тухай цөөнгүй мэдээлэл баримт, архивын баримт бичиг байгаа учраас гүнзгийрүүлэн судалж, судалгааны бие даасан объект болгох шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны бүтээлийн онолын үндэслэл, үндсэн асуудлын мөн чанарыг тодорхойлоход чиглэгдсэн нэгдүгээр бүлэг хэдийгээр тоймлон тайлбарласан шинжтэй боловч эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөний онол, түүхийн асуудлыг тодорхой хэмжээгээр гаргаж чадсан, арга зүйн хувьд оновчтой болсон гэж хэлэх үндэстэй юм.

“Монголд чөлөөт хэвлэл үүссэн нь, түүний хөгжлийн үе шат” хэмээх хоёрдугаар бүлэгт зохиогч энэ асуудлыг чөлөөт хэвлэлийн хөгжлийн эхэн үе (1990-1998), чөлөөт хэвлэлийн хөгжлийн цэгцрэл (self-organizing) үе (1998-2008 он), чөлөөт хэвлэлийн төлөвшлийн үйл явц эрчимжсэн үе (2008 оноос өнөөг хүртэл) гэсэн гурван үед хуваан

үзсэн нь судлаачдын анхаарлыг татах асуудал мөн. Учир нь судалгааны аливаа судлагдахууны хөгжлийг тодорхой үе шатад хуваан үзэх, үечлэлийг тогтоох багагүй судалгаа, мэдрэмж, түүх, онол, практик, арга зүйн тодорхой мэдлэг шаарддаг амаргүй асуудал байдаг. Энэхүү амаргүй асуудлыг оновчтой шийдвэрлэж чадсан нь энэ бүтээлийн гол ололтын нэг мөн гэдгийг онцлон хэлэх хэрэгтэй. Тиймээс судалгааны ажлын удирдагч бөгөөд номын редактор профессор Ж.Батбаатар “Аливаа үзэгдэл, үйл явцыг шинжлэх ухаанчаар судлах нэгэн гол түлхүүр болсон түүхэн хөгжлийн үечлэлийг хийж чөлөөт хэвлэлийн хөгжлийн эхлэл үе (1990-1998 он), чөлөөт хэвлэлийн хөгжлийн цэгцрэл үе (1998-2008 он), чөлөөт хэвлэлийн төлөвшлийн үйл явц эрчимжсэн үе (2008 оноос өнөөг хүртэл) хэмээх гурван үе шатанд хуваан тус бүрийнх нь онцлогийг хэвлэлийн баримтад хийсэн шинжилгээнд тулгуурлан гаргасан нь Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшлийн зүй тогтолт үйл явцыг харуулж чадсан юм” (Б.Галаарид, 2018) гэж бодитой дүгнэлт өгчээ.

Судлаач чөлөөт хэвлэлийн хөгжлийн эхний үед 1990-ээд оны үед анхны чөлөөт хэвлэл гарч эхэлсэн нөхцөл байдал, нөлөөлсөн хүчин зүйлс, цаг үеийн гол гол үйл явдал болон “Шинэ толь”, “Ардчилал”, “Үг”, “Үндэсний дэвшил”, “Бодлын солбицол”, “Ил товчоо”, “МН-Өнөөдөр”-ээс эхлээд орон нутгийн хэвлэлүүд, төрийн мэдлийн томоохон сонинууд, анхны багц

хэвлэлүүд, төрөлжсөн хэвлэлүүд хүртэлх олон арван сониныг тоймлон судалж, тэдний онцлог шинжийг тодорхой жишээ баримтын үндсэн дээр гаргаж өгсөн бол чөлөөт хэвлэлийн хөгжлийн цэгцрэл үед УИХ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг батлан гаргаснаар төрийн мэдэлд байсан ХМХ-үүд бие даан гарч чөлөөт хэвлэлийн эгнээнд шилжин, төрийн монопол устаж, хэвлэлийн зах зээл дэх чөлөөт хэвлэлийн гол өрсөлдөгч байсан төрийн хэвлэлүүд адил тэгш зарчмаар өрсөлдөөнд оролцох шаардлагатай болсныг онцлон тэмдэглэж, энэ үеийн нөлөө бүхий сонинуудын нийтлэлд дүн шинжилгээ хийх замаар онцлог шинжийг гаргаж өгсөн нь оновчтой болжээ. Мөн цахим сэтгүүл зүй эх сууриа тавьж, шар сонинууд эрчимтэй хөгжих хандлага болсон шалтгаан зэргийг ул суурьтай гаргаж өгөхийг оролдсон нь нэн сайшаалтай юм. Харин энд шүүмжлэлтэй хандах нэг зүйл бол чөлөөт хэвлэлийн хөгжилд “Үнэн” сонины үзүүлсэн нөлөө, тухайн үеийн олон нийтийн сэтгэл зүйд давлагаа үүсгэсэн нийтлэлүүдийн талаар тун бага хөндсөн нь учир дутагдалтай юм. “Үнэн” сонин хэдийгээр намын хэвлэмэл байсан ч тухайн үед нийгмийн олон асуудалд чөлөөтэй хандаж, Улс төрийн товчооны гишүүдийг хүртэл нэр зааж шүүмжилж байсан билээ. Ялангуяа 80-аад оны сүүлчээр гарсан асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт хурц дайчин нийтлэлүүд нь чөлөөт хэвлэлийн уур амьсгалыг авчрахад тодорхой нөлөө үзүүлс-

нийг судлаач бид мартаж учиргүй юм.

Судлаач чөлөөт хэвлэлийн төлөвшлийн үйл явц эрчимжсэн үе 2008 оноос эхэлснийг тодорхойлохдоо тухайн жилүүд дэх сонины зах зээлийн борлуулалт, захиалгын статистик үзүүлэлтийн харьцуулсан судалгаа тэргүүтэй хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзсэнээ дурджээ. Тоон үзүүлэлт бол харгалзан үзэх хүчин зүйлийн нэг боловч гол үзүүлэлт биш юм. Гол нь контент-анализын аргаар нийтлэлийн бодлого, сэдвийн хүрээ, тэдний нийгэмд үзүүлсэн нөлөө, хүрсэн үр дүн, сэтгүүлчдийн сэтгэлгээнд болон уран чадварт гарсан өөрчлөлт зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэх сэтгүүл зүйн судалгааны тогтсон шалгууруудыг

харгалзан үзсэн бол илүү оновчтой болох байжээ. Гэхдээ үүнийг судлаач дараа дараагийн судалгааны бүтээлүүдэд харгалзан үзнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ үеийн тогтмол хэвлэлийг судлахдаа

зохиогч сонины нийтлэлийн агуулга руу орж, нэлээд үндэслэлтэй, шинжлэх ухаанч үнэлэлт өгч, дүгнэлт хийхийг оролдсоныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Судлаач “1996, 2006 онуудын өдөр тутмын сонинуудын

нийтлэлийн агуулгатай харьцуулбал 2016 он гэхэд сонинууд нийгмийн хурц эмзэг сэдвүүдийг түлхүү нийтэлж, дата сэтгүүл зүйн элементүүдийг нэвтрүүлж, тодорхой сэдвийг далайцтай хөнддөг болсон ахиц дэвшил ажиглагдаж байна”

(Б.Галаарид, 2018) гэж дүгнэсэн нь үүний тод жишээ юм.

Номын “Чөлөөт хэвлэлийн өнөөгийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйл”, “Чөлөөт хэвлэлийн тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам” хэмээх хоёр хэсгээс бүрдсэн “Чөлөөт хэвлэлийн

хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам” хэмээх гуравдугаар бүлэгт судлаач чөлөөт хэвлэлийн өнөөгийн байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлт болгон мэргэжлийн салба-



Судлаач Б.Галааридын нэг сэдэвт бүтээлийг бүхэлд нь дүгнэж үзвэл чөлөөт хэвлэлийн түүх, онолын асуудлыг нэлээд өргөн хүрээнд системтэй авч үзсэн, чөлөөт хэвлэлийн хөгжлийн үечлэлийг арга зүйн хувьд зөв оновчтой боловсруулж чадсан, чөлөөт хэвлэлийн өнөөгийн байдалд нухацтай дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй асуудлууд болон тэднийг шийдвэрлэх арга замыг зөв шинжлэх ухаанчаар тодорхойлсон, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон баримт мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэд оруулсан, мэдээллийн багтаамж, үнэлэлт дүгнэлт, онол-практикийн хувьд ач холбогдолтой сайтай чамбай бүтээл болжээ.



рын бодлого, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, улс төрийн орчин, тэдний хэрэгжилтийн болон үзүүлэх нөлөө, чөлөөт хэвлэлийн эдийн засаг, дэд бүтцийн орчин, чөлөөт хэвлэлийн олон улсын жишиг хандлага, мэдээллийн аюулгүй байдал зэрэг үзүүлэлтийг авч, тэдний тодорхой жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарласан нь судалгааны арга зүйн хувьд оновчтой болжээ. Угаа-саа чөлөөт хэвлэлийн өнөөгийн нөхцөл байдлыг дээрх шалгуурын тусламжтайгаар тодорхойлох, ойлгох боломжтой.

Судлаач Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд тулгамдаж буй асуудлыг хэвлэлийн хараат бус байдал, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн зохицуулалтын хүрээнд дэлгэрэнгүй авч үзээд дээрх асуудлуудыг Монгол Улсын төр, Засгийн газраас чөлөөт хэвлэлийг дэмжих бодлогоо нарийвчлан тодорхойлох, Үндэсний сэтгүүл зүйн хөгжлийн үзэл баримтлалыг батлан гаргах, олон нийтийн медиа боловсролыг дээшлүүлэх, сэтгүүл зүйн мэргэжлийн байгууллага улсын хэмжээнд ганц байхыг хуульчлах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэнтэй санал нэг байна. Харин энэ бүлэгт чөлөөт хэвлэлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэх талаар нэмж тусгасан бол илүү үр өгөөжтэй болох байжээ. Учир нь чанартай, мэдлэгтэй боловсон хүчингүйгээр чөлөөт хэвлэлийн хөгжлийг төсөөлөх боломжгүй юм.

Судлаач Б.Галааридын нэг сэдэвт бүтээлийг бүхэлд нь дүгнэж үзвэл чөлөөт хэвлэлийн түүх, оно-

лын асуудлыг нэлээд өргөн хүрээнд системтэй авч үзсэн, чөлөөт хэвлэлийн хөгжлийн үечлэлийг арга зүйн хувьд зөв оновчтой боловсруулж чадсан, чөлөөт хэвлэлийн өнөөгийн байдалд нухацтай дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй асуудлууд болон тэднийг шийдвэрлэх арга замыг зөв шинжлэх ухаанчаар тодорхойлсон, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон баримт мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэд оруулсан, мэдээллийн багтаамж, үнэлэлт дүгнэлт, онол-практикийн хувьд ач холбогдолтой сайтай чамбай бүтээл болжээ. Сүүлийн үед судалгааны бүтээлүүдээ хэвлүүлсэн залуу судлаачдын (насаараа бус эрдмийн зэрэг хамгаалсан оны хувьд) бүтээлүүдээс дээрх шинжээрээ ялгарч байгааг онцлон хэлбэл зохино. Үүнд судлаачид өөрөө олон жил чөлөөт хэвлэлд ажиллаж, сүүлийн жилүүдэд Монголын сэтгүүлчдийн байгууллагыг тэргүүлж байсан туршлага, сэтгүүл зүйн суурь мэдлэг, уран бүтээлч хүний бүтээлч сэтгэлгээ чухал үүрэг гүйцэтгэсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Эцэст нь багш, судлаач хүний хувьд монголын сэтгүүл зүйн судлалыг нэг шинэлэг бөгөөд чанартай бүтээл баяжуулсанд баяртай байгаагаа хэлье.

Эшлэл

1. Галаарид Б. (2018) Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ. Ху 29-30.
2. Зулькафиль М. (2015) Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть I. УБ. Ху 246.

3. Батзориг Т. (2019) Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ. Ху 41.
4. Галаарид Б. (2018) Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ. Ху 4.
5. Галаарид Б. (2018) Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ. Ху 118.
6. Мөнхзориг Н. (2012) Монголын шог, хошин нийтлэл: уламжлал, шинэчлэл. УБ.
7. Наранчимэг М. (2021) “Монголын нууц товчоо”-г шинжлэн судлахуй. УБ.
8. Өнөрсайхан Т. (2019) Монголын арилжааны телевизүүд: түүх, онол, арга зүй. УБ.
9. Сандагсүрэн Д. (2021) Л.Түдэвийн нийтлэлийн онцлог, ур чадвар. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ариун Л. (2008) Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ.
2. Ариунзаяа Н. (2014) Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ.
3. Батзориг Т. (2019) Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ.
4. Галаарид Б. (2018) Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ.
5. Зулькафиль М. (2015) Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть I. УБ.

Summary

The purpose of this critique is to review the monograph of Dr. B. Galaarid, a researcher of journalism, titled “Development and Maturation of Mongolian Free Press,” and to evaluate its theoretical and practical benefits and shortcomings. The author highlights the specifics of each chapter, and offers some methodological recommendations that need to be considered in future research. It also describes the contribution of this work to journalistic research.